



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 1 сарын 17 өдөр

Дугаар А/4

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үл хөдлөх хөрөнгийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Нарангэрэл - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Ц.Мягмарзаяа - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн ахлах референт /зөвшилцсөнөөр/


Б.Баатарцогт - Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/

Б.Урантуяа - Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ахлах нягтлан бодогч /зөвшилцсөнөөр/

Д.Батболд - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үл хөдлөх хөрөнгийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт балансаас балансад шилжүүлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, танилцуулахыг ажлын хэсэг (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013826